

Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт “Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх” сургалт зохион байгуулагдлаа.

Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын ахлах референт А.Баянмөнх, Үнэт цаасны газрын референт Х.Билгүүн, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын ахлах хянан шалгагч А.Авир, Даатгалын газрын мэргэжилтэн Т.Золбоо нар 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс 22-ны өдрүүдэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт томилолтоор ажиллаж “Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох сургагч багш бэлтгэх” сургалтыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Бичил санхүүгийн хөгжлийн сан, БСШУСЯ-ны харъяа Насан туршийн боловсролын төв болон тухайн аймаг дахь Монголбанкны салбаруудтай хамтран зохион байгууллаа.

Ажлын хэсгээс 2018 оны 6 дугаар сарын 12-ний өдөр Дорнод аймгийн, 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Сүхбаатар аймгийн, 6 дугаар сарын 18-ны өдөр Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны ажилтнууд, Монголбанкны салбар болон арилжааны банкны ажилтнууд, аймгийн Засаг даргын тамгын газрын ажилтнууд, Цахилгаан станцын ажилтнуудад “Хувийн санхүүгийн төлөвлөлт”, “Мөнгөний үнэ цэнэ ба мөнгөө хэрхэн зөв удирдах вэ?”, “Хуримтлал ба хадгаламж”, “Татвар”, “Зээл”, “Өрхийн төсөв”, “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах”, “Хөрөнгө оруулалт ба үнэт цаас”, зэрэг сэдвүүдээр мэдээлэл хийв. Сургалтанд гурван аймгийн санхүүгийн салбарын 74 албан хаагчид хамрагдав.

2018 оны 6 дугаар сарын 13-аас 14-ний өдрүүдэд Дорнод аймаг дахь “Насан туршийн боловсролын төв”-ийн 23 сургагч багш нарт, 2018 оны 6 дугаар сарын 16-аас 17-ны өдрүүдэд Сүхбаатар аймаг дахь “Насан туршийн боловсролын төв”-ийн 18 сургагч багш нарт, 2018 оны 6 дугаар сарын 19-өөс 21-ны өдрүүдэд Хэнтий аймаг дахь “Насан туршийн боловсролын төв”-ийн 33 сургагч багш нарт “Банк санхүүгийн байгууллага”, “Эрсдэл, эрсдэлээс хамгаалах арга”, “Даатгал”, “Хөрөнгө оруулалт ба үнэт цаас”, “Үнэт цаасны зах зээлийн өнөөгийн байдал”, “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах нь” зэрэг сэдвүүдээр хичээл зааж, орон нутгийн сургагч багш нарт дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.

Томилолтын үеэр орон нутгийн сэтгүүлчидтэй уулзалт хийж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан “Санхүүгийн боловсрол олгох”, “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” нь сэдвээр мэдээлэл хийж, иргэд олон нийтэд санхүүгийн мэдээллийг хэрхэн ойлгомжтой хүртээмжтэй хүргэх талаар харилцан санал бодлоо солилцож, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн сонин телевизүүдэд ярилцлага, мэдээ өгч ажилласан.





